

ХАДГАЛАМЖИЙН
ДААТГАЛЫН
КОРПОРАЦИ
Deposit Insurance Corporation Of Mongolia

10 жил

ЖИЛИЙН ТАЙЛАН

2023

АГУУЛГА

01

КОРПОРАЦИЙН ЗАСАГЛАЛ

ҮНДЭСНИЙ ХОРОО	12
БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	13

02

КОРПОРАЦИЙН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ДААТГАЛЫН ХУРААМЖ ТӨВЛӨРҮҮЛЭХ	16
ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	18
БАНКАНД САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	23
ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ХӨРӨНГИЙГ УДИРДАХ	28
БАНКНЫ ХЯНАЛТ ШАЛГАЛТ	32

03

КОРПОРАЦИЙН БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ ХӨГЖҮҮЛЭЛТ	32
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭРЭГЖИЛТ	33
САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ ДЭХ ОРОЛЦОО	34
ГАДААД ХАРИЛЦАА	36
ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ХАРИЛЦАА	48
ДОТООД АУДИТ	54

04

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

САНХҮҮГИЙН ТАЙЛАН	56
-------------------------	----



ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН КОРПОРАЦИ

Үйл явдлын товчоон

2013

<p>2013.01.10</p> <p>“Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай” хууль батлагдав.</p>	<p>2013.06.14</p> <p>Хадгаламжийн даатгалын корпораци байгуулагдав.</p>	<p>2013.08.16</p> <p>Банкнуудад гишүүн банкны гэрчилгээ олгож эхэлсэн.</p>	<p>2013.10.02</p> <p>Төрийн банканд санхүүгийн дэмжлэг үзүүлэв.</p>	<p>2013.12.21</p> <p>Олон улсын хадгаламжийн даатгагчдын холбоонд 72 дахь гишүүнээр элсэв.</p>
---	---	--	---	--

2014

2015

<p>2014.08.13</p> <p>БНСУ-ын хадгаламжийн даатгалын корпорацитай санамж бичиг байгуулав.</p>	<p>2014.10.24</p> <p>ОУХДХ-ын “Банк өөрчлөн байгуулах нөхөн төлбөр олгох” төрлөөр оны шилдгээр шалгарав.</p>	<p>2015.03.24</p> <p>Японы хадгаламжийн даатгалын корпорацитай санамж бичиг байгуулав.</p>	<p>2015.07.24</p> <p>Тайваний Хадгаламжийн даатгалын корпорацитай санамж бичиг байгуулав.</p>	<p>2015.09.02</p> <p>“Санхүүгийн боловсролыг сайжруулах хөтөлбөр” хэрэгжүүлж эхлэв.</p>
--	--	--	---	---

2016

2017

<p>2016.08.05</p> <p>ОХУ-ын хадгаламжийн даатгалын агентлагтай санамж бичиг байгуулав</p>	<p>2016.08.05</p> <p>АНДБНХ-ын “Актив хөрөнгийн эргэн төлөлтийг сайжруулах нь” сэдэвт олон улсын семинар зохион байгуулав.</p>	<p>2017.03.11</p> <p>Дэлхийн банк хадгаламжийн даатгалын үндсэн зарчмын дагуу үнэлгээ хийв.</p>	<p>2017.07.16</p> <p>Бүгд найрамдах Индонези Улсын хадгаламжийн даатгалын корпорацитай санамж бичиг байгуулав.</p>
---	--	---	--

2018

<p>2018.02.08</p> <p>БДМХДТ хуульд нэмэлт өөрчлөлт оруулж УИХ-аар батлуулан, банкнуудад хяналт, шалгалт хийх эрхтэй болов.</p>	<p>2018.04.01</p> <p>Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн болов.</p>	<p>2018.11.22</p> <p>Single Customer View /SCV/ загварыг боловсруулж батлуулав.</p>
--	--	---

2019

2019.04.08

Татан буугдсан Капитал банкны хадгаламж эзэмшигчдэд даатгалын нөхөн төлбөр олгох шийдвэр гаргав

2019.04.19

ХААН Банкаар дамжуулан татан буугдсан Капитал банкны хадгаламж эзэмшигчдэд даатгалын нөхөн төлбөр олгож эхлэв.

2020

2020.07.08

“Короновируст халдвар / Ковид-19/ цар тахлын үед мөрдөгдөх хадгаламжийн даатгалын хураамжийн түр журам”-ыг дэсний хорооны 105 дугаар тогтоолоор батлуулав.

2020.07.08

“Короновируст халдвар / Ковид-19/ цар тахлын үед мөрдөгдөх банкны тайлан мэдээ, мэдээлэл ирүүлэх түр журам”-ыг боловсруулж Үндэсний хорооны 106 дугаар тогтоолоор батлуулав.

2020.09.10

“Короновируст халдвар / Ковид-19/ цар тахлын үед мөрдөгдөх нөхөн төлбөр олгох түр журам”-ыг боловсруулж Үндэсний хорооны 111 болон 114 дүгээр тогтоолоор тус тус батлуулав.

2021

2021.03.12

Хадгаламжийн даатгалын корпораци нь Засгийн газраас хэрэгжүүлж буй “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-нд оролцов.

2022

2022.04.08

Татан буугдсан Капитал банкны хадгаламж эзэмшигч нарт нөхөн төлбөр олгох үйл ажиллагаа дуусгавар болов.

2022.06.08

Хадгаламжийн даатгалын корпорацийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч С.Баатарсүрэн 3 жилийн хугацаатайгаар Евро-Ази бүсийн хорооны даргаар сонгогдон ажиллахаар болсон.

2022.12.01

Даатгалын нөхөн төлбөр олгох программ хангамжийг хөгжүүлсэн.

2023

2023.05

Хадгаламжийн даатгалын хамрах хүрээг оновчтой тодорхойлох загвар боловсруулсан.

2023.06.28

ОУХДХ-ны ЕвроАзи бүсийн хорооны жилийн уулзалт, “Ялгавартай хураамжийн тогтолцоог хэрэгжүүлэх нь” сэдэвтэй Олон улсын семинарыг Улаанбаатар хотод зохион байгуулав.

2023.06.28

Узбекистан Улсын Банкин дахь иргэдийн хадгаламжийн баталгааны сантай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулав.

2023.06.29

Казахстан Улсын Хадгаламжийн даатгалын сантай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулав.

2023.09.26

Турк Улсын Хадгаламжийн даатгалын сантай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулав.



Хадгаламжийн даатгалын
Үндэсний хорооны даргын

МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм хүндэт гишүүн банкнууд, тэдгээрийн харилцах, хадгаламжийн данс эзэмшигч болон корпорацийн нийт ажилтан та бүхэндээ Хадгаламжийн даатгалын корпорацийн Үндэсний хорооны гишүүдийн нэрийн өмнөөс мэндчилэн, 2023 оны жилийн тайланг танилцуулахад таатай байна.

Хадгаламжийн даатгалын корпораци нь санхүүгийн салбарын дархлаанд чухал үүрэгтэй зохицуулагч байгууллага бөгөөд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн тулгуур багана болсон гишүүн байгууллагын нэг билээ.

Корпораци нь Банкны дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийг банкны салбарын хууль, эрх зүйн шинэчлэлтэй уялдуулах зарчмыг баримтлан 2021 онд Улсын Их Хурлаар баталсан Банкны тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн тухай хууль болон “Банкны салбарын шинэтгэлийн хөтөлбөр”-т нийцүүлэн Монгол Улсын Засгийн Газар болон Монголбанкнаас авч хэрэгжүүлж буй шинэ санаачилга, хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлж, гишүүн банкнуудтайгаа хамтын ажиллагаагаа өргөжүүлж, ялгавартай хураамжийн тогтолцоог олон улсын стандартад нийцүүлэн нэвтрүүлэх тал дээр анхаарч ажиллаа.

Хадгаламжийн даатгалын корпораци нь 10 жилийн ойн арга хэмжээний хүрээнд Монгол Улсад анх удаа Евро-Азийн бүсийн хорооны 13 дахь удаагийн жилийн хурал, “Ялгавартай хураамжийн тогтолцоог хэрэгжүүлэх нь” сэдэвт олон улсын семинарыг амжилттай зохион байгууллаа. Бодлого тодорхойлж хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагын хувьд Үндэсний хорооны гишүүд цаашид баримтлах дунд болон урт хугацааны бодлогыг танилцуулж, хэлэлцүүлээ.

Хадгаламжийн даатгалын сангийн орлого нь байгуулагдсан цагаасаа өнөөг хүртэл тогтвортой өсөж 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 678.2 тэрбум төгрөгт хүрч, хөрөнгө оруулалтын орлогын өсөлтийн эзлэх хувь цаашид ч нэмэгдэх хандлагатай байна.

Өнгөрсөн хугацаанд банкны салбарын эрх зүйн зохицуулалтыг шинэчилсний үр дүнд хадгаламж эзэмшигчийн банканд итгэх итгэл бэхжиж нийт давхардсан тоогоор 6.5 сая харилцах, хадгаламжийн данс эзэмшигчид хадгаламжийн даатгалд даатгагдсан байна.

Олон улсын валютын сан, Дэлхийн банк, Олон улсын хадгаламжийн даатгагчдын холбоо, Банкны хяналт, шалгалтын Базелын хорооноос хэрэгжүүлж буй удирдамж, зөвлөмжтэй корпорацийн үйл ажиллагааг нийцүүлсний үр дүнд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Хадгаламжийн даатгалын корпораци болж бэхжээд байна.

Бидэнтэй хамтран ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагууд, гишүүн банкнууд, олон улсын байгууллагууд, Монгол Улсад Хадгаламжийн даатгалын тогтолцоог анхлан нэвтрүүлэх үйлсэд хамтран зүтгэсэн хамт олон, үе үеийн удирдлага, ажилтнууд та бүхэндээ талархал илэрхийлж, амжилт бүтээлийн дээдийг хүсэн ерөөе.

ХҮНДЭТГЭСЭН
МОНГОЛБАНКНЫ ТЭРГҮҮН
ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ

Г.ДӨЛГӨӨН





Гүйцэтгэх захирлын
МЭНДЧИЛГЭЭ



Монгол улсын санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах, банкны салбарын хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах эрхэм зорилготой Хадгаламжийн даатгалын корпораци үүсэн байгуулагдсаны 10 жилийн ой тохиосон тайлант онд, хийж хэрэгжүүлсэн ажлаа хүндэт гишүүн банкнууд, тэдгээрийн харилцагч, хадгаламж эзэмшигч нартаа танилцуулж байгаадаа баяртай байна.

Хадгаламжийн даатгалын корпораци өнгөрсөн 10 жилийн хугацаанд, Банкн дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн хүрээнд хадгаламжийн даатгалын үйл ажиллагааг төр засгийн бодлого, хууль тогтоомжтой уялдуулан хэрэгжүүлэх, олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх, гишүүн банкнуудын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн ажлуудыг амжилттай хэрэгжүүлж ирлээ.

Хадгаламжийн даатгалын сан нь 2013 онд анх 92.2 тэрбум төгрөгийн эхлэлтийн хөрөнгөтэй үйл ажиллагаагаа эхлүүлж байсан бол 2023 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар сангийн хөрөнгө 678.2 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Монгол улсын Хадгаламжийн Даатгалын Корпораци нь 2022 оны 6 сараас эхлэн Евро-Ази Бүсийн Хороог тэргүүлэн ажиллаж байна.

Тайлант онд бид Олон улсын хадгаламжийн даатгагчдын холбооны Евро-Ази бүсийн хорооны 2023 оны жилийн уулзалт, “Ялгавартай хураамжийн тогтолцоог хэрэгжүүлэх нь” сэдэвт олон улсын семинарыг воркшоп хэлбэрээр Улаанбаатар хотноо амжилттай зохион байгууллаа. Тус арга хэмжээ нь Олон улсад Монгол Улсын Хадгаламжийн даатгалын корпорацийн байр суурийг бэхжүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан үйл явдал боллоо.

Мөн Евро-Ази бүсийн гишүүн улс хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр Узбекистан, Казахстан болон Турк улсын хадгаламжийн даатгагч байгууллагуудтай “Хамтын ажиллагааны харилцан ойлголцлын санамж бичиг” байгууллаа.

Хадгаламжийн даатгалын корпораци нь гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн актив хөрөнгийн удирдлагын сайн туршлага, сүүлийн үеийн чиг хандлага, аргачлал зэргийг судлах зорилгоор Олон улсын нийтийн актив удирдлагын форум/IPAF/-д гишүүнээр элслээ.

Дэлхийн банкны санхүүжилтээр эхлүүлсэн нөхөн төлбөр олгох программ хангамжийн бэлэн байдал болон аюулгүй байдлыг илүү анхаарч туршилт сайжруулалтыг хийж ажиллаа. Ингэхдээ программын зүгшрүүлэлт, гарын авлагуудыг хүлээн авч, гишүүн банкнуудтай холболт хийх бэлтгэл ажлыг хангаж, баазын өргөтгөл хүчин чадлыг нэмэгдүүлсэн.

Манай байгууллага санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүний хувьд иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн олон улсын арга хэмжээ болох “Дэлхийн мөнгөний долоо хоног-2023”, “Дэлхийн хуримтлалын өдөр-2023” аяныг банк санхүүгийн байгууллагуудтай хамтран зохион байгууллаа.

Цаашид Монгол Улсын хадгаламжийн даатгалын тогтолцоог улам өргөжүүлэн, үйл ажиллагаагаа шинэ шатанд хүргэхийн төлөө бид бүхэн хичээн ажиллах болно. Та бүхэндээ эрүүл энх, амжилт бүтээлийн дээдийг хүсэн ерөөе!

ХҮНДЭТГЭСЭН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

С.БААТАРСҮРЭН





ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН КОРПОРАЦИ

Монголын Хадгаламжийн даатгалын корпораци нь Банкн дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн хүрээнд төрөөс үүсгэн байгуулсан ашгийн төлөө бус хуулийн этгээд бөгөөд хадгаламжийн даатгалын үйл ажиллагааг эрхлэн явуулдаг.

АЛСЫН ХАРАА

Санхүүгийн системийн хэрэглэгчдийн итгэлийг хүлээсэн, Олон улсад болон Монголдоо танигдсан нэр хүнд бүхий хадгаламжийн даатгагч болох.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Монгол улсын санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах, банкны салбарын хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахад оршино.

ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН КОРПОРАЦИ

ЗОРИЛГО

- Иргэдийн банканд итгэх итгэлийг бэхжүүлэх
- Санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангахад Корпорацийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх
- Банкны салбарын сахилга батыг сайжруулах
- Зөв засаглалын бүтэц, чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллах

ҮНДЭСНИЙ ХОРОО

Хадгаламжийн даатгалын корпорацийн удирдах дээд байгууллага нь Үндэсний хороо бөгөөд нийт 7 гишүүнтэй байна. Үндэсний хорооны даргаар Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч, гишүүдээр Сангийн яамны төрийн нарийн бичгийн дарга, Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга, Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирал болон Монголбанк, Сангийн Яам, Монголын банкны холбооны төлөөллүүдээс бүрдэнэ.

Үндэсний хороо нь Корпорацийн бүтэц, зохион байгуулалт, холбогдох дүрэм, журмыг батлахаас гадна даатгалын хураамжийн хувь хэмжээг тогтоох, нөхөн төлбөр олгох, хүндрэлийн үед зохих арга хэмжээ авах, хөрөнгө оруулалтыг зохион байгуулахтай шийдвэрүүдийг бүрэн эрхийнхээ хүзээнд гаргаж, Корпорацийн үйл ажиллагаанд хяналт тавих, удирдан чиглүүлэх үүрэгтэй ажилладаг.



Г.ДӨЛГӨӨН
Үндэсний хорооны дарга,
Монголбанкны Тэргүүн
Дэд Ерөнхийлөгч



Т.ЦЭРЭНБАДРАЛ
Үндэсний хорооны гишүүн,
Санхүүгийн зохицуулах
хорооны дэд дарга




Ж.ГАНБАТ
Үндэсний хорооны гишүүн,
Сангийн яамны Төрийн нарийн
бичгийн дарга



Л.АМАР
Үндэсний хорооны гишүүн,
Монголын банкны холбооны
Гүйцэтгэх захирал



Н.БАТСАЙХАН
Үндэсний хорооны гишүүн,
Монголбанкны Ерөнхийлөгчийн
ажлын албаны Санхүүгийн зах
зээлийн асуудал хариуцсан
ахлах референт



С.БААТАРСҮРЭН
Үндэсний хорооны гишүүн,
Хадгаламжийн даатгалын
корпорацийн
Гүйцэтгэх захирлын үүрэг
гүйцэтгэгч



Б.СҮХ-ОЧИР
Үндэсний хорооны гишүүн,
Сангийн яамны Санхүүгийн
бодлогын газрын дарга

КОРПОРАЦИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хадгаламжийн даатгалын корпораци нь 2 газар, 7 хэлтэс, 2 алба, 1 Үндэсний хорооны нарийн бичгийн даргын орон тоотойгоор үндсэн үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.



Хадгаламжийн даатгалын корпораци 2023 онд бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэх, хүний нөөцийн чадавхи болон хууль, эрх зүйн орчинг сайжруулах, хамтын ажиллагааг бэхжүүлэх, дэвшилтэт технологи, арга ажиллагааг нэвтрүүлэх чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Захиргаа удирдлагын газрын үйл ажиллагаа


Хүний нөөцийн чадавхийг сайжруулах, удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгож, боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулахад анхааран ажилтнуудаа тухай бүр тасралтгүй сурган хөгжүүлж, тэдний ажиллах нөхцөл, цалин урамшуулал, нийгмийн асуудлыг тухай бүр шийдвэрлэн ажиллаж байгаа бөгөөд Хүний нөөцийн эрсдэлтэй холбогдуулан ажилтнуудын цаг ашиглалтыг сайжруулах чиглэлээр үе шаттай арга хэмжээ авч ажиллаж байна.

Корпорацийн ажилтнуудыг дараахь сургалтуудад хамруулсан. Үүнд:

- Арилжааны банкнуудын SCV загвараар мэдээлэл бэлтгэх;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт;
- Эрүүл мэндийн даатгалын ач холбогдол;
- Стресс гэж юу вэ? Хэрхэн стрессээс ангид байх вэ?
- Хүний эрхийг хангах, хамгаалах, хүний эрхийн боловсрол;
- Ажлын байрны дарамт, ажлын байрны хүчэрхийллэс урьдчилан сэргийлэх;
- Засгийн газрын худалдан авах ажиллагааны удирдлага, зохион байгуулалт” АЗ сертификат сургалт;
- Архив, албан хэрэг хөтлөлтийн онол, арга зүй сэдэв;
- Мэдээлэх үүрэгтэй этгээдүүдэд чиглэсэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх;

Авлигын эсрэг үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор жил бүр “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-г боловсруулж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хуулийн өөрчлөлт, шинэчлэлттэй холбогдуулан, Хадгаламжийн даатгалын корпорацийн Гүйцэтгэх захирлын тушаалаар 2 журам шинээр батлан хэрэгжүүлэв. Мөн Үндэсний хорооны тогтоолоор Корпорацийн дүрэмд нэмэлт өөрчлөлт орж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.



КОРПОРАЦИЙН
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ДААТГАЛЫН ХУРААМЖ ТӨВЛӨРҮҮЛЭХ


Хадгаламжийн даатгалын хураамжтай холбоотой үйл ажиллагааг “Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль” болон Хадгаламжийн даатгалын Үндэсний хорооноос баталдаг “Хадгаламжийн даатгалын хураамжийн журам”, “Банкны тайлан болон мэдээ, мэдээлэл ирүүлэх журам”-аар тус тус зохицуулдаг.

Хадгаламжийн даатгалын корпораци нь 2022 онд Коронавируст халдвар Ковид-19-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хэрэгжих хугацаа дахин сунгасантай холбогдуулан Коронавируст халдвар КОВИД-19-ын цар тахлын үед мөрдөгдөх хадгаламжийн даатгалын хураамжийн түр журмын 2.1 дэх хэсэгт “улирлын хураамж тооцох суурь нь өмнөх улирлын сар бүрийн эцсийн өдрийн нийт харилцах, хадгаламжийн дүнгээс хуулийн 7.1 болон 7.2.2, 7.2.3 дахь заалтад заасан харилцах, хадгаламжийн болон гадаад валютын харилцах, хадгаламжийн дүнг хассан дүн байна” гэж заасны дагуу 2020 оны III, IV, 2021, 2022, 2023 оны I улирлын хураамжийг тооцсон билээ.

Хадгаламжийн даатгалын Үндэсний хорооны 2015 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 23 тоот тогтоолоор банкнуудаас авах улирлын хураамжийн хувийг улиралд 0.0625 хувиар тогтоож, 2015 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэлсэн бөгөөд Үндэсний хорооны 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 169 тоот тогтоолоор 2023 онд мөрдөгдөх улирлын хураамжийн хувийг хэвээр байлгахаар тогтоосон.

Даатгалын улирлын хураамж /тэрбум төгрөг/


Банкны систем, Хураамжийн дүн



Хадгаламжийн даатгалын корпораци нь гишүүн банкнуудаас улирлын хураамжаар нийт 67.3 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн.

Гишүүн банкнуудын төлсөн хураамж 2023 он

Системийн нөлөө бүхий банкнууд



Бусад банкнууд




Төвлөрүүлсэн нийт хураамжийн орлогын 91 хувийг банкны системд нөлөө бүхий 5 банк бүрдүүлсэн бол үлдсэн 9 хувийг бусад 7 банк бүрдүүлж байна.

Хадгаламжийн даатгалын корпорац 2013 оноос хойш нийт 443 тэрбум төгрөгийн хадгаламжийн даатгалын хураамжийн орлогыг татан төвлөрүүлсэн бөгөөд улирлын хураамжийн орлогын өөрчлөлтийг улирал бүрээр доор харуулав.

Хураамжийн орлогын улирлын өсөлт

Хураамжийн орлого /тэрбум төгрөг/



ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хадгаламжийн даатгалын корпораци нь даатгалын тохиолдол бий болохоос өмнө гишүүн банкнуудаас хадгаламж эзэмшигчдийн мэдээллийг хүлээн авч, даатгалын нөхөн төлбөрийн хэмжээг тооцоолон зохих бэлтгэлийг тогтмол ханган ажилладаг бөгөөд даатгалын тохиолдол үүссэн үед нөхөн төлбөр олгох банкаар дамжуулан хадгаламж эзэмшигчдэд даатгалын нөхөн төлбөрийг олгодог. Өнгөрөгч онд даатгалын нөхөн төлбөр олгох программ хангамжийг хөгжүүлсэн бөгөөд уг программ хангамжтай болсноор хүний оролцоог багасгаж, даатгалын нөхөн төлбөрийн тооцооллыг богино хугацаанд хийж, нөхөн төлбөр олгох үйл явцыг хурдан шуурхай болгох төдийгүй нөхөн төлбөр олгох банкны ачааллыг бууруулах боломжтой болсон.

Программ хангамж нь 3 хэсгээс бүрдэнэ.



Даатгалын нөхөн төлбөр олгох программ нь энгийн үед улирал бүр гишүүн банкнуудаас харилцах, хадгаламжийн данс эзэмшигчдийн мэдээллийг хүлээн авч болзошгүй нөхөн төлбөрийн тооцооллыг хийн нөхөн төлбөрийн жагсаалт боловсруулж, холбогдох статистик тайлан мэдээнүүдийг гарган ажилладаг. Дараах байдлаар болзошгүй нөхөн төлбөрийн тооцооллыг хийдэг.

Үүнд:

- Гишүүн банкнуудаас харилцах, хадгаламжийн дансны SCV мэдээллийг авах
- Өгөгдлийн бүрэн бүтэн байдлыг шалгах
- Нөхөн төлбөрийн тооцоолол хийх
- Тайлан мэдээ гаргах

Даатгалын тохиолдлын үед албадан татан буугдсан банкны эрх хүлээн авагчаас мэдээлэл хүлээн авах, хүлээн авсан мэдээлэлд дүн шинжилгээ, тооцоолол хийж, нөхөн төлбөр олгох, тайлан мэдээ гаргах, оролцогч талуудтай хамтран ажиллаж, даатгалын тохиолдлын үед хадгаламж эзэмшигчийн гомдлыг хурдан шуурхай шийдвэрлэх боломжтой. Даатгалын тохиолдлын үед нөхөн төлбөр олгох банкны ачааллыг бууруулж программ хангамж дараах үйл явцын дагуу нөхөн төлбөр олголтыг хийнэ.

Үүнд:

- SCV дата мэдээлэл хүлээн авах
- Өгөгдлийн бүрэн бүтэн байдлыг шалгах
- Даатгалын нөхөн төлбөрийн тооцоолол хийж, шалгах
- Баталгаажуулалт хийх
- Нөхөн төлбөр олголт хийх
- Корпораци, Банкны эрх хүлээн авагч, Нөхөн төлбөр олгох банкнууд нь нэгдсэн системд холбогдон гомдол бүртгэж, шийдвэрлэх
- Тайлан мэдээг өөрсдийн хүссэн загвар форматаар гаргаж авах

Корпораци нь энэ онд программын бэлэн байдал болон аюулгүй байдлыг илүү анхаарч туршилт сайжруулалтыг хийн ажиллаа. Ингэхдээ программын зүгшрүүлэлт, гарын авлагуудыг хүлээн авч, гишүүн банкнуудтай холболт хийх бэлтгэл ажлыг хангаж, баазын өргөтгөл хүчин чадлыг нэмэгдүүлсэн. Үүний дагуу эхний ээлжинд Стэнд-бай гэрээ байгуулсан Төрийн банкттай программын холболт хийх ажлыг эхлүүлсэн ба уг ажлын хүрээнд хамтарсан ажлын хэсэг байгуулан, программын танилцуулга, холболт зааварчилгааны талаар уулзалт зохион байгуулан туршилтыг эхлүүлээд байна.

Бид цаашид бүх гишүүн банкнуудтай энгийн үеийн холболтыг хийж харилцах, хадгаламжийн данс эзэмшигчдийн мэдээллийг хүлээн авах үйл ажиллагааг зүгшрүүлэхээр ажиллаж байна.

Хадгаламжийн даатгалын хамрах хүрээ

Хадгаламжийн даатгалын хамрах хүрээ гэдэг нь даатгалд хамаарах бүтээгдэхүүн үйлчилгээ болон даатгалын тохиолдол бий болох үед нөхөн төлбөр олгох дээд хэмжээг хэлнэ.

Хамрах хүрээ нь хязгаарлагдмал, хадгаламж эзэмшигчдийн хувьд итгэл төрөхүйц, дийлэнх хэсгийг хамарсан байх хэрэгтэй гэж үздэг ч зах зээлийн зарчмаараа хадгаламжийн нэлээд хэсэг нь орхигддог байна. Улс орон бүр өөрсдийн эдийн засаг болон нийгмийн хүчин зүйлсээс гадна хадгаламжийн даатгалын сангийн хүрэлцээ, зорилтот түвшингээс хамааруулан хамрах хүрээг янз бүр тогтоодог бөгөөд тодорхой хугацааны давтамжтай шалгаж, шаардлагатай тохиолдолд шинэчлэн тогтоодог байна.

Манай улсын хувьд хадгаламжийн даатгалын хамрах хүрээг төгрөг болон гадаад валютын харилцах, хадгаламжийн дансны 20 сая хүртэлх төгрөгийг даатгана гэж тогтоосон байдаг. Олон улсын хадгаламжийн даатгалын холбооноос (IADI) хамрах хүрээг 3-5 жил тутам эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан шалгахыг зөвлөдөг. Иймд Корпорацийн зүгээс 2020 онд хамрах хүрээг судалж үзэхэд хуульд заасан түвшин нь нийт хадгаламж эзэмшигчдийн 98 хувь, нийт харилцах, хадгаламжийн дансны 24 хувийг даатгаж байгаа тул хангалттай түвшинд байна гэж дүгнэгдсэн.

Хамрах хүрээтэй холбоотой 2016 оноос хойших судалгаанд хадгаламжийн даатгалын хамрах хүрээг оновчтой тодорхойлох загвар тэгшитгэлийг санал болгож байгаа бөгөөд энэ нь сүүлийн жилүүдэд илүү дэлгэрэнгүй судлагдаж байна. Иймд олон улсын чиг хандлагад нийцүүлэн хамрах хүрээг өнөөгийн нийгэм эдийн засгийн нөхцөлд оновчтой эсэхийг загвар ашиглан дахин шалгах шаардлага үүссэн.

Бид хадгаламжийн даатгалын хамрах хүрээг тогтоох загвартай болох зорилгоор зөвлөхийн сонгон шалгаруулалт зарлан сонгож, дотоодын зөвлөхтэй хамтран ажилласан. Зөвлөх хадгаламжийн даатгалын оновчтой түвшинг тодорхойлох загварыг Davila, Goldstein нарын 2023 онд Journal of Political Economy сэтгүүлд нийтлүүлсэн судалгааны ажлын загварыг ашиглан боловсруулсан бөгөөд даатгалын хураамжтай хувилбараар өргөтгөж загварын тооцооллыг хийсэн. Загварт чанаргүй зээлийн хувь, активын өгөөж, хадгаламжийн хүү, нөхөн барагдуулалтын түвшин, банкнуудын харилцах хадгаламжийн мэдээлэл, хураамж болон бусад параметруудийг ашигласан бөгөөд тооцоолол, калибрац зэргийг R программыг ашиглаж хийсэн.

Даатгалын нөхөн төлбөр олгох суваг


Олон улсын хадгаламжийн даатгагчдын холбооноос 2023 онд гаргасан “Одоо цагт болон ирээдүйд даатгалын нөхөн төлбөр олгох нь: Тулгарч буй асуудлууд, сайжруулах арга зам болон чиг хандлага” сэдэвт судалгааны ажилд 2016-2021 оны хооронд хадгаламжийн даатгагч нар дараах сувгуудаар дамжуулан даатгалын нөхөн төлбөрийг олгосон байна.

Үүнд:

- Хадгаламжийн даатгагч
- Нөхөн төлбөр олгох банк
- Бусад агент
- Татан буугдсан байгууллага
- Гүүр банк
- Актив, пассив хүлээн авсан банк
- Бусад суваг

Дээрх хугацаанд нийт нөхөн төлбөр олголтын 62 хувийг нөхөн төлбөр олгох банк болон бусад байгууллага, 22 хувийг хадгаламжийн даатгагчид, үлдсэн хувьд нь гар утасны аппликейшн хөгжүүлэх, бусад хэлбэрийг хослуулах байдлаар шийдсэн байна.

Даатгалын нөхөн төлбөр олголтын төрөл



Эх сурвалж: Reimbursing depositors now and in the future, IADI, June 2023.

Энэхүү судалгаанд 2016-2021 онд үүссэн даатгалын тохиолдолд нэг болон түүнээс дээш нөхөн төлбөр олголтын төрлийг хослуулжээ. Даатгалын нөхөн төлбөр олголтын төрлийн хувьд цахим болон банкны шилжүүлэг ихэнх хувийг эзэлж байна. Мөн АТМ болон чек ашиглан бэлэн мөнгөөр нөхөн төлбөр олгохыг түлхүү ашигласан байна. Харин хадгаламж эзэмшигчийн нөхөн төлбөрийг байршуулсан тусгай картыг даатгалын тохиолдлын 16 хувь буюу хамгийн бага ашиглажээ. Даатгалын тохиолдлын онцлогоос шалтгаалан бусад олголтын төрлийг ашигласан бөгөөд энэ нь 25 хувийг эзэлж байна.

Хадгаламжийн даатгалын хамрах хүрээ

Хамрах хүрээг улс орон бүр өөрсдийн нийгэм эдийн засгийн хүчин зүйлсээс гадна Хадгаламжийн даатгалын сангийн хүрэлцээ, зорилтот түвшингээс хамааруулан тодорхой хугацаанд шинэчлэн тогтоодог (Core principles for effective deposit insurance systems 2009). Хамрах хүрээний түвшинг бага тогтоовол хадгаламж эзэмшигчид жижиг, сул банкнуудыг орхиж, санхүүгийн тогтвортой байдалд сөрөг нөлөөлдөг бол хэт өндөр тогтоох нь банкны сахилга бат, хариуцлагыг бууруулах сул талтай. Тиймээс хадгаламжийн даатгалын хамрах хүрээг тогтоохдоо Олон улсын хадгаламжийн даатгагчдын холбоо болон бусад олон улсын байгууллагуудаас гаргасан зөвлөмж, зааврыг мөрдлөг болгон ажилладаг.

Олон улсын хадгаламжийн даатгагчдын холбоо нь даатгалын хамрах хүрээг тогтоохдоо инфляци, нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн болон бусад хүчин зүйлсийг анхаарч, тогтмол давтамжтай шалгахыг зөвлөдөг. (Core principles for effective deposit insurance systems 2009). Мөн 2013 онд гаргасан зөвлөмжид “80/20-ийн дүрэм” буюу нийт харилцах, хадгаламж эзэмшигчдийн 80 хувь нь, нийт харилцах хадгаламжийн хэмжээний 20 хувь нь даатгалд хамрагдсан байвал тохиромжтой гэж үзсэн байдаг (Enhanced Guidance for Effective Deposit Insurance Systems: Deposit Insurance Coverage 2013).

Харин 2016 онд Eduardo Davila болон Itay Goldstein нар банк дампуурах магадлал, хүлээгдэж буй нийгмийн ахиу зардал зэрэг хувьсагчдыг сонгон авч хадгаламжийн даатгалын оновчтой хамрах хүрээг тодорхойлох тэгшитгэлийг боловсруулсан. Davila Goldstein нар нь 2021 онд судалгааг дахин сайжруулж Колумба улсын хадгаламжийн даатгалын хамрах хүрээг нэмэгдүүлсэн байна (Optimal Deposit Insurance 2016, Coverage Levels in Deposit Insurance: to Increase or not to Increase 2020).

Мөн бусад улс орнууд хадгаламжийн даатгалын хамрах хүрээгээ тогтоосон туршлагаас харахад нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүнийг тодорхой хэмжээнд нэмэгдүүлсэн дүнгээр тогтоосон нь ажиглагдсан.

Нийт хадгаламж эзэмшигчид болон нийт харилцах хадгаламжийг даатгасан байдал /Чиг үүргээр/



Эх сурвалж: IADI survey, 2022

Олон улсын хадгаламжийн даатгагчдын холбооны 2022 оны судалгаанаас харахад Pay-box чиг үүрэгтэй улсууд дунджаар харилцах, хадгаламж эзэмшигчдийн 90 хувь харилцах, хадгаламжийн 39 орчим хувийг даатгадаг байна. Харин Risk-minimiser чиг үүрэгтэй улсууд бусад чиг үүрэгтэй харьцуулахад харилцах хадгаламжийн хэмжээг илүү өндөр буюу 50 хувь даатгаж байна.

БАНКАНД САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монголбанкнаас банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээний хүрээнд актив, пассивыг шилжүүлэх болон тусгай зориулалтын банк байгуулах арга хэрэгслийг ашиглах тохиолдолд Корпорациас банкинд санхүүгийн дэмжлэг үзүүлдэг. Ингэхдээ “Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай” хуульд заасны дагуу санхүүгийн дэмжлэг, түүнтэй холбоотой гарах зардлын нийлбэр нь даатгалын нөхөн төлбөр олгоход шаардагдах хөрөнгө, түүнтэй холбоотой гарах зардлын нийлбэрээс бага байх тохиолдолд санхүүгийн дэмжлэгийг үзүүлэх буюу зардлын харьцуулалтыг хийж, бага зардалтай арга хэмжээг ашиглах зохицуулалттай байдаг.

Хадгаламжийн даатгалын корпорацийн анхны санхүүгийн дэмжлэг үзүүлсэн тохиолдол 2013 онд тохиож байсан бөгөөд тухайн үед Монголбанкны Ерөнхийлөгчийн А157 тоот тушаалаар Хадгаламж банкныг албадан татан буулгах шийдвэрийг гаргаж, тус банкны актив, пассивыг Төрийн банкинд шилжүүлж байсан. Хадгаламжийн даатгалын корпорациас актив, пассивын зөрүү болох 119.9 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг Төрийн банкинд үзүүлсэн ба тухайн үед Корпораци үүсгэн байгуулагдаад удаагүй, сангийн хөрөнгө хангалттай хэмжээнд бүрдээгүй байсан тул дээрх санхүүгийн дэмжлэг үзүүлэх эх үүсвэрийг Монголбанкнаас 10 жилийн хугацаатай зээлийн гэрээ байгуулан авч байсан.

Зээлийн зарцуулалт:




Зээлийн эргэн төлөх эх үүсвэр

1. Хадгаламж банкны эрх хүлээн авагчийн төлүүлсэн активын орлого
2. Төрийн банкны хувьчлалаас Хадгаламжийн даатгалын корпорацид ногдох хувьцааны нэрлэсэн үнээс давсан хэсэг
3. Төрийн банкны хувьцааны ногдол ашиг
4. Хадгаламжийн даатгалын корпорацийн бусад орлогыг тус тус барьцаалсан байдаг.

Зээлийн гэрээний хугацаа энэ жил дуусгавар болж байгаа тул Корпораци 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр зээлийн үлдэгдэл төлбөрийг бүрэн төлж, зээлийн гэрээг дуусгавар болгосон.

Корпорациас Төрийн банканд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн үйл ажиллагааны зураглал:




Зээл зориулалтын дагуу ашиглагдаж, Төрийн банк нь салбартаа системийн нөлөө бүхий томоохон банкнуудын нэг болсон нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлсэн гэж дүгнэж байна.

Бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээнд ХДК-ийн оролцоо

Олон улсад санхүүгийн байгууллагыг хүндрэлд орохоос сэргийлж өөрчлөн байгуулах 10 төрлийн арга хэрэгслийг ашигладаг байна. Тухайн санхүүгийн байгууллагын онцлог шинж чанар болон хадгаламжийн даатгагчийн эрх үүргээс хамааран бүтцийн өөрчлөлтийн арга хэрэгслийг авч хэрэгжүүлдэг. Банкнаас бусад санхүүгийн байгууллагуудад авч хэрэгжүүлж буй бүтцийн өөрчлөлтийн арга хэрэгслүүдэд бага зэрэг өөрчлөлт оруулан банканд авч хэрэгжүүлэх боломжтой байдаг.

Санхүүгийн байгууллагуудад авч хэрэгжүүлж буй бүтцийн өөрчлөлтийн арга хэрэгслүүд




Эх сурвалж: Ways to resolve financial cooperative while keeping the Cooperative structure -2021.12.14

■ Боломжгүй
 ■ Боломжтой

Дээрх судалгаанд нийт 29 улс хамрагдсан бөгөөд хүндрэлд орсон байгууллагыг татан буулгаж, нөхөн төлбөр олгох, актив, пассив шилжүүлэг болон сайн, муу хөрөнгийн загвар арга хэрэгслийг хамгийн өргөн ашигладаг байна. Үүний дараа дахин хөрөнгөжүүлэх болон гүүр банкны арга хэрэгслийг түлхүү ашиглаж байна. Эдгээрээс 6 арга хэрэгслийг хадгаламжийн даатгагчид банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээний үед авч хэрэгжүүлдэг байна.

Хадгаламжийн даатгагчдын ашиглаж буй бүтцийн өөрчлөлтийн арга хэрэгслүүд



ОУХДХ нь жил бүр гишүүн байгууллагуудын үйл ажиллагааны чиглэл, эрх мэдэл, чиг үүрэгт тогтмол судалгаа хийж, үр дүнд суурилан шаардлагатай зөвлөмж баримт бичгийг боловсруулдаг. Дээрх судалгаанд нийт 108 хадгаламжийн даатгагчид хамрагдсан бөгөөд актив, пассив шилжүүлэг -83, гүүр банк -71, татан буулгах -91, нөхөн төлбөр олгох -91, санхүүгийн баталгаа үзүүлэх -43, бусад -48 бүтцийн өөрчлөлтийн арга хэрэгслийг ашиглаж байгаа талаар мэдээлсэн байна. Эдгээр 108 байгууллагаас 26 нь бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх тохиолдолд тусгай төлөөлөгч болон бүрэн эрхт төлөөлөгч, 33 нь банкны эрх хүлээн авагчаар ажиллах зохицуулалттай бөгөөд ихэнх нь алдагдлыг бууруулах чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Корпорацийн хувьд эдгээр арга хэрэгслүүдээс актив, пассив шилжүүлэг, гүүр банк байгуулах болон нөхөн төлбөр олгох арга хэмжээний үед Монголбанктай хамтран ажиллаж байна.


Гүүр банк (Тусгай зориулалтын банк) байгуулах

Хадгаламжийн даатгагчдын хувьд банкныг татан буулгаж, нөхөн төлбөр олгох арга хэрэгслийг түлхүү ашигладаг. Үүний дараа актив, пассив шилжүүлэг болон гүүр банк байгуулах арга хэрэгслийг өргөн ашиглаж байгаа бөгөөд сүүлийн 5 жилийн хугацаанд хадгаламжийн даатгагчдын хувьд гүүр банкны арга хэрэгслийг авч хэрэгжүүлж буй байдал нь 45% -70% хүртэл огцом өссөн байна.

Гүүр банк гэдэг нь Төвбанк болон бусад эрх бүхий байгууллагаас бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээний хүрээнд хүндрэлд орсон банкны үйл ажиллагаа болон актив, пассивыг шилжүүлэн авч тодорхой хугацаанд удирдаж буй банкныг хэлнэ. Өөрөөр хэлбэл хүндрэлд орсон банкны актив, пассивыг шилжүүлэн авах банк байхгүй, тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд цаг хугацаа их шаардагдах эсхүл тус банкныг татан буулгах хүртэл тодорхой хугацаанд хадгаламжийн даатгагч болон бусад эрх бүхий байгууллагын зүгээс гүүр банкныг байгуулж, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалж, хүндрэлд орж буй банкны үйл ажиллагааг үргэлжлүүлэхийн зэрэгцээ тухайн банкныг худалдах үйл ажиллагаанд бэлтгэдэг.

Хадгаламжийн даатгагчдын хувьд алдагдлыг бууруулах болон эрсдэлийг бууруулах чиг үүргийн хүрээнд гүүр банкныг байгуулж, тусгай төлөөлөгч болон удирдлагын багт нь орж ажилладаг байна. Харин хадгаламжийн даатгалын тогтолцоо өндөр хөгжсөн орнууд болох Америк, Япон, Канад, Солонгосын хувьд гүүр банкныг өөрсдийн харьяа охин байгууллага хэлбэрээр байгуулж, үйл ажиллагааг нь хэрэгжүүлдэг байна.

Гүүр банкныг дараах тохиолдолд байгуулна. Үүнд:



Санхүүгийн тогтвортой байдлыг хангагч байгууллагуудын шийдвэрийн дагуу санхүүгийн системд доголдол үүсч, хадгаламж эзэмшигчид нэг дор хадгаламжаа татах үзэгдлээс сэргийлэх буюу банкны харилцах, хадгаламж эзэмшигчдийг хохиролд орохоос хамгаалж дээрх тохиолдолд гүүр банкныг байгуулна. Ихэнх тохиолдолд 2 жилийн хугацаатайгаар байгуулж, шаардлагатай тохиолдолд хугацааг сунгадаг. Гүүр банкны заасан хугацааг сунгаж ажиллаад үр дүнд хүрэхгүй байх тохиолдолд дараагийн шатны арга хэмжээг авах буюу гүүр банкныг татан буулгах процесст бэлтгэдэг. Гүүр банк нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Үүнд:

- Хүндрэлд орсон санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг үргэлжлүүлж, хувьцааг зарах
- Даатгагдсан хадгаламжийг шилжүүлэх
- Тухайн байгууллагыг нэгтгэх ,салгах
- Нэг болон түүнээс дээш талуудад актив, пассивыг хэсэгчлэн шилжүүлэх

Дээрх үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлээд гүүр банкны үйл ажиллагааг дуусгавар болгох эсхүл амжилтгүй болсон тохиолдолд татан буулгадаг байна.

ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ХӨРӨНГИЙГ УДИРДАХ


ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН САНГИЙН УДИРДЛАГА

Хадгаламжийн даатгалын сангийн хөрөнгө нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 678.2 тэрбум төгрөгт хүрсэн. Үүний 443.2 тэрбум төгрөгийг хураамжийн орлогоор, 302.2 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтын үйл ажиллагаагаар төвлөрүүлсэн ба 33.8 тэрбум төгрөгийг үндсэн үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Хадгаламжийн даатгалын сангийн хөрөнгийн бүтэц

	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	Өсөлт%
Нийт сангийн хөрөнгө	105.5	157.8	213.7	255.7	314.4	318.8	433.9	463.2	541.3	578.3	678.2	17.3%
Хураамжийн орлого	19.2	52.4	79.8	111.3	147.4	190.4	238.7	282.1	327.4	375.5	443.2	18.0%
Хөрөнгө оруулалтын орлого	1.7	16.0	39.5	69.5	110.1	144.4	187.1	227.3	240.6	265.9	302.2	13.6%
Ерөнхий болон удирдлагын зардал	0.3	1.5	3.0	5.1	7.5	10.4	13.7	17.9	22.6	27.4	33.8	23.3%

Хадгаламжийн даатгалын сангийн хөрөнгийн бүтэц, өсөн нэмэгдсэн дүнгээр



Хадгаламжийн даатгалын сангийн хүрэлцээ

Сангийн хүрэлцээ нь гишүүн банкнуудын даатгагдсан харилцах, хадгаламж эзэмшигчдэд нөхөн төлбөр олгоход хадгаламжийн даатгалын сангийн хөрөнгө хэр хүрэлцээтэй байгаагаар тодорхойлогдоно. Сангийн хүрэлцээг тооцохдоо банк тус бүрийн тухайн тайлант хугацааны эцсийн байдлаарх болзошгүй нөхөн төлбөрийн хэмжээг, хадгаламжийн даатгалын сангийн хөрөнгийн хэмжээнд харьцуулан тооцдог.

Хадгаламжийн даатгалын сангийн хүрэлцээ

Нийт харилцах, хадгаламжийн дансны үлдэгдэл	40.1 их наяд төгрөг
Нийт даатгагдсан харилцах, хадгаламжийн дансны үлдэгдэл	9.2 их наяд төгрөг
Хадгаламжийн даатгалын сангийн хэмжээ	678.2 тэрбум төгрөг
Сангийн хөрөнгийн нийт харилцах, хадгаламжид эзлэх хувь	1.7 хувь
Сангийн хөрөнгийн нийт даатгагдсан харилцах, хадгаламжид эзлэх хувь	7.4 хувь


Хадгаламжийн даатгалын сангийн хөрөнгө тайлант хугацаанд 678.2 тэрбум төгрөгт хүрсэн байгаа нь нийт харилцах, хадгаламжийн 1.7 хувь, нийт даатгагдсан харилцах, хадгаламжийн 7.4 хувьтай тэнцэж байна. Энэ нь даатгалын тохиолдол гарахад одоогийн байгаа нийт хадгаламжийн даатгалын сангийн хөрөнгө нь банкны системд нөлөө бүхий 5 банкнаас бусад банкнуудын харилцах, хадгаламжийн данс эзэмшигчдийн нөхөн төлбөрийг төлөхөд хүрэлцээтэй байна.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хадгаламжийн даатгалын корпорацийн хөрөнгө оруулалтын багц нь тайлант хугацаанд өмнөх оноос 6.8 хувиар өсөж 668.8 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд багцын 70 хувийг Төв банкны хадгаламж, 19 хувийг Засгийн газрын бонд, 6 хувийг Засгийн газрын батлан даасан үнэт цаас, 5 хувийг Гадаад зах зээлээс худалдан авсан бондууд тус бүр эзэлж байна.

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа

Хөрөнгө оруулалтын багц 2023.12.31-ний байдлаар




Хөрөнгө оруулалтын өгөөжийн орлого нь тайлант хугацаанд 37.5 тэрбум төгрөгт хүрч, батлагдсан төлөвлөгөөнөөс 15 хувиар давж биелсэн. Хөрөнгө оруулалтын өгөөжийн орлого нэмэгдэхэд Төв банк 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдөр бодлогын хүүгээ 13 хувь хүртэл өсгөх арга хэмжээ авсан нь нөлөөлсөн.

Хөрөнгө оруулалтын өгөөж /тэрбум төгрөг/

I улирал	8.3
II улирал	9.5
III улирал	10.1
IV улирал	9.6

Хөрөнгө оруулалтын хүүгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Хөрөнгө оруулалтын хүүгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг 2013-2023 оны байдлаар харуулбал:





КОРПОРАЦИЙН
БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА

БАНКНЫ ХЯНАЛТ ШАЛГАЛТ

Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Монголбанкны Ерөнхийлөгч буюу Улсын ерөнхий байцаагчийн баталсан Хадгаламжийн даатгалын корпорацийн Улсын байцаагчийн дүрмийн хүрээнд эрх бүхий албан тушаалтан, улсын байцаагч хяналт шалгалтын үйл ажиллагааг хийж гүйцэтгэж байна.

Хяналт шалгалтын чиг үүргийг өргөжүүлэх хүрээнд ижил төстэй хадгаламжийн даатгагчид хяналт шалгалтыг хэрхэн хэрэгжүүлдэг, бусад зохицуулагч байгууллагуудын хяналт шалгалтаас ялгаатай онцлог байдлын талаар судалгааг хийсэн. Мөн хянан шалгагчийн гарын авлагыг боловсруулан батлуулж, чиг үүргээ өргөжүүлэх хүрээнд ажиллаж байна.

Хадгаламжийн даатгалын корпораци нь 2023 онд Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25¹.1 дэхь хэсэгт заасан хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд газар дээрх хяналт шалгалтыг нийт 9 банканд, зайны хяналт шалгалтыг нийт 12 банканд улирал бүр хийсэн байна.

Хадгаламжийн даатгалын корпорацийн улсын байцаагчид бүрэн эрхийн хүрээнд нийт 8 гомдол мэдээллийг хүлээн авч 6 зөрчлийг бүрэн шалган шийдвэрлэсэн бол 2 зөрчлийг шалган шийдвэрлэж байна. Зөрчлийн хэргээр нийт 403.0 сая төгрөгийн хураамж, 112.5 сая төгрөгийн торгууль оногдуулснаас 63.7 төгрөгийн хураамж, 31.5 сая төгрөгийн торгууль төлөгдсөн байна.

Мөн Хадгаламжийн даатгалын корпорацийн SCV загварын тайлан мэдээлэл ирүүлээгүй 2 банканд зөрчил шалган шийдвэрлэх зөрчлийн хэрэг нээж зөрчлийн хуулийн дагуу 20.0 сая төгрөгийн торгууль ногдуулж ажиллсан байна.

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ ХӨГЖҮҮЛЭЛТ

Мэдээллийн технологийн хэлтэс нь даатгалын нөхөн төлбөрийн систем, дотоод үйл ажиллагааг дэмжих ERP систем болон бусад системүүдийн хэвийн найдвартай ажиллагааг хангах, Корпорацийн үйл ажиллагааг хэвийн явуулах мэдээллийн технологийн ашиглалт, аюулгүй байдал, холбогдох дүрэм, журмыг батлуулж хэрэгжүүлэх, дотоод гадаад сүлжээг зохион байгуулах ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Даатгалын нөхөн төлбөрийн системийг арилжааны банкнуудтай холбож харилцах, хадгаламжийн данс эзэмшигчдийн мэдээллийг хүлээн авах холболт, туршилтын ажлуудыг хийж байна. Хадгаламжийн даатгалын корпорацийн мэдээллийн технологийн талаар баримтлах бодлогыг холбогдох хууль эрх зүйн актууд, олон улсын мэдээллийн системийн аюулгүй байдал, нууцлалын стандартад нийцүүлэхээр ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны 27001:2022 стандартыг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭРЭГЖИЛТ

Хуулийн хэлтэс нь Корпорацийн үйл ажиллагаатай холбоотой аливаа тушаал, шийдвэр, гэрээ, санамж бичиг болон бусад эрх зүйн баримт бичгийн төслийн эрх зүйн үндэслэлийг хянаж хуульд нийцүүлэх, байгууллагын эрх зүйн орчныг сайжруулах талаар санал гаргаж, дүрэм журам боловсруулах, Корпорацийн үйл ажиллагаатай холбоотой аливаа зөрчил, маргаантай асуудлын талаар шүүх бусад хууль хяналтын байгууллагад төлөөлөн оролцох үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Энэхүү чиг үүргийн хүрээнд 2023 онд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

1. Корпорацийн үйл ажиллагаатай холбоотой Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгэлтэй доорх хүснэгтэд дурдагдах журамд Захиргааны ерөнхий хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-т /захиргааны хэм хэмжээний актад жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийн явц, үр дүнг тайлагнах/ заасны дагуу тухайн журмын хэрэгжилтийг хангаж ажиллаж байгаа Корпорацийн бүтцийн нэгжүүдээс тайлан нэгтгэн авч түүнд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, хэрэгжилтэд гарах аливаа асуудлаар санал зөвлөгөө өгч удирдлагаар хангаж ажиллаа.

2. Хууль хяналтын байгууллагад Корпорацийг төлөөлөн оролцох чиг үүргийн хүрээнд:

Журам	Батлагдсан огноо	Дагаж мөрдөгдөх огноо	Хариуцсан нэгж
Даатгалын тохиолдолд олон нийтэд мэдээлэл хүргэх журам	2018.08.16	2018.09.05	ГГХАХ
Банкинд санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам	2018.11.22	2019.01.11	НТЭУГ
Банкны тайлан мэдээ, мэдээлэл ирүүлэх журам	2019.12.13	2020.01.31	НТЭУГ
Даатгалын нөхөн төлбөр олгох журам	2018.11.22	2019.01.11	НТЭУГ
Хадгаламжийн даатгалын хураамжийн журам	2019.12.13	2020.01.31	НТЭУГ

Корпорацийг үйл ажиллагаатай холбоотой аливаа зөрчил маргаан үүссэн тохиодолд хуулийн хэлтсээс нэхэмжлэгч, хариуцагчаар болон бусад холбогдох хууль хяналтын байгууллагад төлөөлөн оролцдог бөгөөд 2023 оны байдлаар Иргэний хэргийн шүүхэд хянагдаж байгаа 5, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар шилжүүлсэн 2 хэрэгт төлөөлөн оролцсон байна.

3. Хуулийн хэлтэс нь Корпорацийн нийт ажилчдад хууль, эрх зүйн мэдлэг олгох сургалтыг тодорхой сэдвийн хүрээнд зохион байгуулдаг билээ. Эдгээр сургалтын зорилго нь нийт ажилчдын хууль зүйн мэдлэгийг дээшлүүлэх цаашлаад аливаа хууль тогтоомжийг хэрэгжилтийг хангаж ажиллах талаар нэгдсэн нэг ойлголт өгөхөд чиглэдэг болно.

4. Корпорацийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой аливаа тушаал, шийдвэр, гэрээ, санамж бичиг болон бусад эрх зүйн баримт бичгийн төслийн эрх зүйн үндэслэлийг хянаж хуульд нийцүүлэн ажилладаг.


САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ ДЭХ ОРОЛЦОО

Хадгаламжийн даатгалын корпораци нь 2018 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн болж улирал бүр ээлжит хуралдаанд оролцож байгаа ба 2023 онд нийт 4 удаа хуралд оролцон, бусад гишүүн байгууллагуудтай санал солилцож хамтран ажилласан.


2023 онд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

1. Хөнгөлөлттэй хүүтэй орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөрийг засгийн газарт шилжүүлэх тухай
2. Тогтвортой хөгжлийн зорилтуудын санхүүжилтийн таксономи батлах тухай
3. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл
4. Хэрэглээний зээлийн өр, орлогын харьцааны болон хугацааны хязгаарлалтыг банкнаас бусад санхүүгийн салбарт мөрдүүлэх саналын тухай
5. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн болон төв банкны арилжааны нэгдсэн системийг нэвтрүүлэх ажлын хэрэгжилтийн талаар танилцуулга
6. 2024 оны хуралдааны тов батлах тухай

2023 онд санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн хуралдсан байдал:



2024 оны санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн хуралдааны тов






ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА
ОЛОН УЛСЫН ХАДГАЛАМЖИЙН ДААТГАГЧДЫН ХОЛБОО (IADI)



Олон улсын хадгаламжийн даатгагчдын холбоо нь хадгаламжийн даатгалын системийн Олон улсын стандарт тогтоогч байгууллага бөгөөд дэлхийн санхүүгийн системийн тогтвортой байдалд хувь нэмэр оруулах, хадгаламжийн даатгагчдын болон бусад санхүүгийн тогтвортой байдлыг хангагч байгууллага хоорондын хамтын ажиллагааг дэмжих зорилгоор 2002 онд үүсгэн байгуулагдсан. 2023 оны байдлаар үндсэн гишүүн 93, хамтын ажиллагаатай 11, түнш 17 байгууллагын бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна.



ОУХДХ-ны үндсэн гишүүд нь улс орнуудын хадгаламжийн даатгалын байгууллагуудын төлөөллөөс бүрдэх бол түншүүдэд хадгаламжийн даатгалын тогтолцоог бий болгохыг зорьж буй улс орнуудын санхүүгийн тогтвортой байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудын төлөөлөл багтдаг.

Хамтран ажиллагч байгууллагууд нь ОУХДХ-той гэрээ хэлэлцээр байгуулсан Олон улсын санхүүгийн байгууллага, мэргэжлийн байгууллагуудаас бүрдэнэ.

Олон улсын хадгаламжийн даатгагчдын холбооны бүрэлдэхүүн улс орнууд



Бүс нутгуудын эрх ашиг, сонирхол, ижил төстэй асуудлыг тусгах, хоорондоо мэдээлэл, санал солилцох журмаар гишүүд **Африк, Ази-Номхон далай, Карибын тэнгис, Европ, Евро-Ази, Латин Америк, Ойрхи дорнод болон Хойд Африк, Хойд Америк** гэсэн 8 бүсийн хороонд харьяалагддаг. Бүсийн хороодын дарга нар Удирдах зөвлөлд шийдэл санал болгох, Удирдах зөвлөлийн хуралд бүсийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг танилцуулах, мэдээлэх, үйл ажиллагаагаа тайлагнах үүрэгтэй.

Монгол улсын Хадгаламжийн даатгалын корпораци
нь 2022 оноос Евро-Азийн бүсийн хороог тэргүүлэн
ажиллаж байна.



ОЛОН УЛСЫН ХАДГАЛАМЖИЙН ДААТГАГЧДЫН ХОЛБООНЫ АЗИ-НОМХОН ДАЛАЙН БҮСИЙН ХОРООНЫ 21 ДЭХ УДААГИЙН ЖИЛИЙН УУЛЗАЛТ, ОЛОН УЛСЫН БАГА ХУРАЛД ОРОЛЦЛОО. (2023 оны 5 дугаар сар)

Хадгаламжийн Даатгалын Корпорацийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч С.Баатарсүрэн Япон улсын Фүкүока хотноо 2023 оны оны 5-р сарын 29-нээс 6-р сарын 1-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Ази-Номхон далайн бүсийн хороо/APRC/-ны 21 дэх удаагийн жилийн уулзалтанд оролцлоо. Тус хуралд нийт 35 улсын 100 орчим төлөөлөгчид оролцсон. Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч С. Баатарсүрэн нь Ази-Номхон далайн бүсийн хорооны захиргаа удирдлагын томоохон асуудлууд, Стратегийн тэргүүлэх чиглэл үйл ажиллагааны төлөвлөгөөний хамтарсан ажлын хэсгийн тайлан, түүнчлэн Филиппиний Хадгаламжийн Даатгалын Корпорацийн (PDIC) Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх захирал ноён Роберто Таныг APRC-ийн дэд даргаар дахин томилох асуудлыг хэлэлцсэн.



21th IADI APRC Annual Meeting

Date : Wednesday, May 31, 2023



“Шинэ эрин рүү шилжих нь: Хадгаламжийн даатгагчдын уламжлалт арга хэрэгслийг шинэчлэх, шинэ хандлагыг нэгтгэх нь” сэдэвт Олон улсын бага хурал гурван салбар хуралдаанаас бүрдсэн бөгөөд дэлхийн болон бүс нутгийн чиг хандлага, болзошгүй эрсдэлийг хэлэлцэх, хадгаламжийн даатгагчдыг шинэчилсэн арга хэрэгслээр хөгжүүлэх, шинэ бүс нутгийн хэтийн төлөвөөс судалгаа хийх, чадавхийг бэхжүүлэх чиглэлээр бүс нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх асуудлаар хэлэлцүүлэг хийгдсэн ба чуулганы үеэр оролцогчдын дийлэнх нь санхүүгийн хяналт шалгалт, хадгаламжийн даатгалын асуудлаар улс бүрийн мэргэжилтнүүдтэй санал бодлоо солилцсон юм.



УНГАР УЛСЫН ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН САНГААС ТУРШЛАГА СУДЛАХ УУЛЗАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ. (2023 оны 5 дугаар сар)

Унгар улсын Хадгаламжийн даатгалын сантай холбоо харилцаа тогтоож, Корпорацийн төлөөлөл дараах чиглэлүүдээр туршлага судаллаа.

Үүнд:

- Дотоод бүтэц, зохион байгуулалт, засаглал
- Мэдээллийн технологийн хөгжүүлэлт, тулгамдсан асуудлууд
- Single Cistomer View загвар, нөхөн төлбөрийн үйл ажиллагаа, программ хангамж, татан буугдсан Сбербанкны санхүүжилт болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны өөрчлөлт
- Олон нийтийн санхүүгийн боловсрол, хадгаламжийн даатгалын тогтолцоог таниулах үйл ажиллагаа зэрэг багтсан.

ЕВРО-АЗИЙН БҮСИЙН ХОРООНЫ 2023 ОНЫ УУЛЗАЛТ БОЛОН ОЛОН УЛСЫН СЕМИНАРЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ. (2023 оны 6 дугаар сар)

2023 IADI Eurasia Regional Committee Annual Meeting and International Workshop



Евро-Азийн бүсийн хорооны 13 дахь удаагийн жилийн уулзалтыг Монгол улсад анх удаа зохион байгууллаа. Уулзалтад Евро-Азийн бүсийн хорооны гишүүн 6 улсын 15 төлөөлөгч биечлэн оролцож, бүс нутгийн тайлан, тулгамдаж буй асуудлуудаа хэлэлцэн, Стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг байгуулахаар санал нэгдлээ. Олон улсын семинарыг 18 улсын 40 гаруй зочин төлөөлөгч, илтгэгч болон Монгол улсын Төв банк, Санхүүгийн зохицуулах хороо, арилжааны банкнуудын төлөөллөөс бүрдсэн банк санхүүгийн салбарын оролцогч нарын дунд амжилттай зохион байгуулсан.

“Ялгавартай хураамжийн тогтолцоог хэрэгжүүлэх нь” сэдэвт Олон улсын семинар гурван салбар хуралдаанаас бүрдсэн бөгөөд Олон улсын стандарт, улс орнуудын сайн туршлага, мэдээллийн технологийн дэвшлийг ялгавартай хураамжийн тогтолцоог боловсронгуй болгоход ашиглах, хэрхэн хэрэгжүүлэх талаар илтгэгч нар оролцогчидтой санал бодлоо солилцосны эцэст группээр ажиллан сурч мэдсэн зүйлээ бататгалаа.

Мөн банкны эрсдэлийн үнэлгээг улс орнууд хэрхэн өөрсдийн онцлогт тохируулан хэрэгжүүлсэн туршлагаасаа хуваалцан, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар панел хэлэцүүлэг өрнүүллээ.



Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан гадны зочид төлөөлөгчдийг Чингис хааны музей, Монгол номадик цогцолбороор зочлуулж, үндэснийхээ өв соёлыг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулсан.



ЕВРО-АЗИ БҮСИЙН ГИШҮҮН УЛС ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЛЭЭ. (2023 оны 6, 9-р сар)



Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч С.Баатарсүрэн, Узбекистан улсын Банкин дахь иргэдийн хадгаламжийн баталгааны сангийн захирал Нодир Аббосов нар хоёр талын “Хамтын ажиллагааны харилцан ойлголцлын санамж бичиг”-т гарын үсэг зурсан.



Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч С.Баатарсүрэн, Казахстаны Хадгаламжийн даатгалын сангийн дарга Адиль Утембаев нар хоёр талын “Хамтын ажиллагааны харилцан ойлголцлын санамж бичиг” байгуулж, гарын үсэг зурлаа.



Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч С.Баатарсүрэн, Турк Улсын хадгаламжийн даатгалын сангийн ТУЗ-ийн гишүүн ноён Исмаиль Гулер нар хоёр талын “Хамтын ажиллагааны харилцан ойлголцлын санамж бичиг” байгуулж, гарын үсэг зурлаа.

**ОЛОН УЛСЫН ХАДГАЛАМЖИЙН ДААТГАГЧДЫН ХОЛБОО/IADI/-НЫ 2023 ОНЫ ЖИЛИЙН ЕРӨНХИЙ УУЛЗАЛТ, ОЛОН УЛСЫН БАГА ХУРАЛД ОРОЛЦЛОО.
(2023 оны 9-р сар)**

Олон Улсын Хадгаламжийн Даатгагчдын Холбооны жилийн ерөнхий уулзалт



Хадгаламжийн даатгалын корпорацийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч мөн Олон улсын хадгаламжийн даатгагчдын холбооны /International association of deposit insurers, IADI/ Евро-Азийн бүсийн хорооны дарга С. Баатарсүрэн нь 2023 оны 09-р сарын 25-29-ний өдрүүдэд АНУ-ын Бостон хотноо Массачусетсийн зээлийн холбооны хувьцааны даатгалын корпорацийн зохион байгуулсан ОУХДХ-ны 22 дахь жилийн уулзалт мөн “Системийн эрсдэлийг амжилттай удирдах нь: Хямралын үеийн хадгаламжийн даатгал” сэдэвт олон улсын бага хуралд оролцов.

Хурлаар дэлхийн санхүүгийн тогтвортой байдалд ОУХДХ-ны гүйцэтгэх үүргийг бэхжүүлэх хууль тогтоомжийн өөрчлөлт, сүүлийн үеийн банкны салбарын хямралын нөлөөллийн талаарх тайлан гаргах төлөвлөгөө зэрэг чухал өөрчлөлтүүдийг онцлон тэмдэглэж мөн холбоо шинэ гишүүдийг хүлээн авч, гүйцэтгэх зөвлөлийн гишүүдийг шинээр сонгов.

Евро-Ази Бүсийн Хорооны ээлжит хурал



Ази-Номхон Далайн Бүсийн Хорооны ээлжит хурал

Санхүүгийн Зохицуулах Хорооны дэд дарга, Хадгаламжийн даатгалын үндэсний хорооны гишүүн Т.Цэрэнбадрал мөн Хадгаламжийн Даатгалын Корпорацийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч С.Баатарсүрэн нар оролцож санал солилцлоо. Тус хурлын үеэр Олон Улсын Хадгаламжийн Даатгагчдын Холбооны ерөнхий нарийн бичгийн дарга хатагтай Эва Хапкес холбооны засаглал, стратегид оруулж буй өөрчлөлтүүд, холбооны сүүлийн үед хийгдэж буй бодлогын ажлуудыг танилцуулсан.



ОЛОН УЛСЫН НИЙТИЙН АКТИВ ХӨРӨНГӨ УДИРДЛАГЫН КОМПАНИЙН ФОРУМ (IPAF)-Д ГИШҮҮНЭЭР ЭЛСЛЭЭ. (2023 ОНЫ 8-Р САР)



INTERNATIONAL PUBLIC AMC FORUM

STABILITY, BETTERMENT OF ASIAN NATIONAL ECONOMIES

Олон улсын нийтийн актив хөрөнгө удирдлагын компанийн форум(IPAF) нь 2013 онд БНХАУ, Казахстан, БНСУ, Тайланд, Вьетнам зэрэг таван улсын 7 төрийн өмчит Актив хөрөнгө удирдлагын корпорациуд болон Азийн хөгжлийн банкны хамтаар төрийн бус байгууллага хэлбэрээр үйл ажиллагаагаа эхлүүлж бүс нутгийн Актив хөрөнгө удирдлагын корпорациудын санхүүгийн салбар дахь идэвхи санаачлага, мэдлэг, мэдээлэл, сайн туршлага зэргийг хуваалцах, түгээх нийтлэг платформыг бие болгох зорилгоор үүсгэн байгуулагдаж дэлхийн өнцөг булан бүрээс актив удирдлагын мэргэжилтнүүдийг цуглуулж, мэдлэг, туршлагаа хуваалцаж, энэ салбарын сүүлийн үеийн чиг хандлага, хөгжлийн талаар бодлого боловсруулдаг.

Мөн уг форум нь активын мэргэжилтнүүдэд төсөл, санаачилгад нэгдэж, хамтран ажиллах талбар болж өгдөг. Одоогийн байдлаар 8 орны 16 гишүүн байгууллагатай Азийн онцгой эрх бүхий олон улсын актив удирдлагын корпораци болон хадгаламжийн даатгагчдын форум болж өргөжин тэлсээр байна.

IPAF нь эдийн засгаа төрөл бүрийн санхүүгийн хямралаас хамгаалахад дэмжлэг туслалцаа үзүүлж байсан төрийн өмчийн нээлттэй активын удирдлагын корпорациудын бизнес, хөрөнгө оруулалтын багц стратеги, туршлага, мэдлэг, мэдээллийг хуваалцаж байдаг бөгөөд Азийн хөгжлийн банк тэргүүтэй төрийн болон хувийн хэвшлийн сургалт, зөвлөгөө, хил дамнасан хөрөнгө оруулалтыг идэвхжүүлдэг.

Монголын Улсын Хадгаламжийн даатгалын корпораци нь гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн цаашид чиг үүргээ нэмэгдүүлэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулахад шаардлагатай актив хөрөнгийн удирдлагын сайн туршлага, сүүлийн үеийн чиг хандлага, аргачлал, хамтын ажиллагаа зэргийг судлахад IPAF-д гишүүнчлэлээр элсэхэд давуу талтай болно. IPAF-д гишүүнээр элссэнээр авлага барагдуулах чиглэлээр эрх үүргээ нэмэгдүүлэн хяналт тавин ажиллах, банкны эрх хүлээн авагчаас мэдээлэл авах тал дээр шаардлага тавих эрх үүргийг олон улсын сайн туршлагаас судлан боловсон хүчнээ чадавхжуулах ач холбогдолтой тул бид 2023 оны 8-р сард тус олон улсын форумд гишүүн байгууллагаар элсэн орсон.

ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ХАРИЛЦАА

Тайлант хугацаанд бид Хадгаламжийн даатгалын тогтолцооны талаар иргэд олон нийтэд мэдээлэл хүргэх, банкны ажилтнуудын мэдлэгийг нэмэгдүүлэх, улмаар иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт болон олон нийтэд чиглэсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулж ажиллаа.

Хадгаламжийн даатгалын тогтолцооны талаар олон нийтэд мэдээлэл хүргэх үйл ажиллагаа

Төрийн болон төрийн бус байгууллагын ажилтан албан хаагчид, Их дээд сургуулийн оюутан залуус, ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад сургалт мэдээллийн арга хэмжээг зохион байгуулж, нийт 1500 гаруй иргэнд мэдээлэл хүргэлээ.



Нийслэлийн жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих төвөөс зохион байгуулсан “Амар байна уу 2023” үндэсний бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаанд оролцож, нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид болон үзэсгэлэн худалдааг сонирхон ирсэн иргэдэд хадгаламжийн даатгалын талаар мэдээлэл хүргэж ажиллаа.



Жил бүрийн 5 дугаар сард уламжлал болон зохион байгуулагддаг “Номын баяр” өдөрлөгийн арга хэмжээнд оролцож, иргэд, олон нийтэд хадгаламжийн даатгалын талаар мэдээлэл хүргэхээс гадна байгууллагаас бэлтгэн гаргасан санхүүгийн боловсролын гарын авлага ном, товхимлуудыг олон нийтэд танилцуулан, түгээж ажиллав.



Гишүүн банкнуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх үйл ажиллагаа

Арилжааны банкны ажилтнуудын Хадгаламжийн даатгалын тогтолцооны талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор Төрийн банк Капитрон банк, Хас банк, Голомт банк, Транс банк, М банк, Богд банк, Худалдаа хөгжлийн банк болон Үндэсний хөрөнгө оруулалтын банкны нийт 900 гаруй ажилтанд сургалт зохион байгуулсан.



Жил бүр уламжлал болгон зохион байгуулагдаг банк хоорондын байт харвааны аварга шалгаруулах тэмцээнийг, Голомт банктай хамтран 2023 оны 8 дугаар сарын 27-ний өдөр, Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн “Байт харвааны 360 төв” талбайд амжилттай зохион байгууллаа.



Санхүүгийн боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагаа

ДЭЛХИЙН МӨНГӨНИЙ ДОЛОО ХОНОГ-2023

Хадгаламжийн даатгалын корпораци нь хүүхэд залууст санхүүгийн боловсролын мэдлэг, мэдээлэл хүргэх, мөн олон нийтэд санхүүгийн салбарын үйл ажиллагааг таниулах зорилготой “Дэлхийн мөнгөний долоо хоног-2023” аяны үйл ажиллагааг “Санхүүгээ удирдаж, Ирээдүйгээ бүтээцгээе” уриан дор бусад байгууллагуудтай хамтран зохион байгуулав.



Аяны хүрээнд Хадгаламжийн даатгалын корпорациас Улаанбаатар хотын Ерөнхий боловсролын 146, 113, 19-р дунд сургуулиудын ахлах ангийн сурагчдад хадгаламжийн даатгалын тухай болон санхүүгийн боловсролын мэдлэг олгох сургалтууд зохион байгуулснаас гадна Дундговь, Баянхонгор, Дархан-Уул, Орхон аймгийн Монголбанкны салбаруудтай хамтран орон нутгийн хүүхэд, залуучуудад чиглэсэн сургалт, мэдээллийн арга хэмжээнүүдийг зохион байгуулсан.



ДЭЛХИЙН ХУРИМТЛАЛЫН ӨДӨР-2023

Хадгаламжийн даатгалын корпораци нь “Дэлхийн хуримтлалын өдөр” аяныг банк санхүүгийн байгууллагуудтай хамтран 7 дахь жилдээ зохион байгууллаа.

“Хамтдаа хуримтлуулж, Ирээдүйгээ бүтээцгээе” уриан дор аяны нээлтийн арга хэмжээг Монголын банкны холбоо, Монголбанк, арилжааны банкнууд, ХБНГУ-ын Шпаркассе банкны Монгол дах сан, Money market ХХК зэрэг байгууллагуудтай хамтран Төв аймгийн Зуунмод хотод, хаалтын арга хэмжээг Өмнөговь аймгийн Даланзадгад хотод тус тус зохион байгуулав.



Аяны хүрээнд Нийслэлийн Баянгол дүүргийн Ерөнхий боловсролын 40 дүгээр сургууль, Америк-Монголын хамтарсан “Шилдэг” сургуулийн нийт 200 сурагчдад хуримтлалын ач холбогдол, хадгаламжийн даатгалын тогтолцооны талаар сургалт мэдээллийн арга хэмжээ зохион байгуулсан. Мөн Дархан-Уул, Орхон, Булган, Хэнтий аймгуудын ЕБС-ийн сурагчдын дунд “Даатгагдсан хадгаламж” сэдэвт эсээ бичлэгийн уралдаан, “Хамтдаа хуримтлуулж, Ирээдүйгээ бүтээцгээе” сэдэвт Тик Ток бичлэг бүтээх уралдаан зэрэг хүүхэд залуучуудад чиглэсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулав.





“Дэлхийн хуримтлалын өдөр-2023” аяны хүрээнд хот болон орон нутгийн нийт 4500 гаруй хүүхэд залууст санхүүгийн боловсролын мэдээлэл хүргэж ажиллав.

Нийгмийн хариуцлагын хүрээнд

Хадгаламжийн даатгалын корпорацийн хамт олон Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэж, 2023 оны 5-р сарын 13-ны өдөр Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн зүүн бүсэд “Улиас, Голт бор” зэрэг навчит болон гоёл чимэглэлийн нийт 100 мод тарьж, эх байгалиа хайрлан хамгаалах, үр хойч үедээ өвлүүлэн үлдээх буянтай үйлсэд хувь нэмрээ орууллаа.



ДОТООД АУДИТ

Дотоод аудитын албаны үйл ажиллагаа:

Дотоод аудитын алба нь Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 19.7 дахь хэсэгт заасны дагуу Хадгаламжийн даатгалын Үндэсний хорооны дэргэд албаны захирал, 3 дотоод аудиторын бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулдаг ба корпорацийн дотоод аудит, хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Дотоод аудитын алба нь Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартын дагуу Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль болон бусад холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд Хадгаламжийн даатгалын корпорацийн үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлэх, зохистой засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоог үнэлж, үйл ажиллагааг сайжруулах чиглэлд дүгнэлт, зөвлөмж өгөх замаар Корпорацийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Нэгжийн үндсэн чиг үүрэг нь Хадгаламжийн даатгалын Үндэсний хорооны баталсан төлөвлөгөөний дагуу аудит хийж Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Үндэсний хороо болон Гүйцэтгэх удирдлагын шийдвэр, баталсан журам, зааврыг Корпораци хэрхэн биелүүлэн ажиллаж байгаад аудит хэрэгжүүлж, үйл ажиллагаа, санхүү, төлбөрийн байдалд дүгнэлт өгч дэмжин туслах юм.


Тайлант жилд Дотоод аудитын албанаас Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд нийт 15 дүгнэлт зөвлөмж өгч, 4 аудитыг нэгжийн түвшинд болон сэдэвчилсэн төлөвлөгөөт байдлаар хэрэгжүүлэн Үндэсний хороонд танилцуулан холбогдох шийдвэр гаргуулж ажиллалаа. Албаны зүгээс Үндэсний хорооноос батлагдсан бодлогын шийдвэрийн биелэлт, корпорацийн ажлын төлөвлөлт, төлөвлөгөөний биелэлт, газар хэлтэс нэгж хоорондын чиг үүргийн уялдаа холбоо, давхардал, тасалдал зэрэгт хяналт тавьж, зөвлөмжийн биелэлтийг хангуулах, үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг өдөр тутамдаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Үндэсний хорооны үйл ажиллагаа:

Хадгаламжийн даатгалын корпорацийн удирдах дээд байгууллага нь Үндэсний хороо юм. Үндэсний хороо нь Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 22.2 дахь хэсэгт заасны дагуу нийт долоон гишүүнээс бүрдэх бөгөөд тус хуулийн 24 дүгээр зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо нь Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу 2023 онд улирал бүр хуралдсан байна.

УИХ-аас 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр баталсан Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу 2023 онд хэмнэлтийн горимыг баримтлан ажиллаж байна.



**ХАРААТ БУС
АУДИТОРЫН ТАЙЛАН**

2023 оны 12-р сарын 31-ний өдрөөр
тасалбар болсон жилийн
СТОУС-ын дагуу илэрхийлэгдсэн
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН КОРПОРАЦИ

Ерөнхий мэдээлэл

Нэр	Хадгаламжийн даатгалын корпораци	
Улсын бүртгэлийн дугаар	9081001124	
Үйл ажиллагааны чиглэл	Хадгаламжийн даатгалын корпораци нь “Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль”-ийн хүрээнд төрөөс үүсгэн байгуулсан ашгийн төлөө бус хуулийн этгээд бөгөөд хадгаламжийн даатгалын үйл ажиллагааг эрхлэн явуулна.	
Гүйцэтгэх удирдлага	Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Санхүү эрхэлсэн захирал	С. Баатарсүрэн Т. Өлзийсүрэн
Төлөөлөн удирдах зөвлөл	Үндэсний хорооны дарга Үндэсний хорооны гишүүн Үндэсний хорооны гишүүн Үндэсний хорооны гишүүн Үндэсний хорооны гишүүн Үндэсний хорооны гишүүн Үндэсний хорооны гишүүн	Г. Энхтайван Ж. Ганбат Т. Цэрэнбадрал Б. Сүх-Очир Н. Батсайхан Л. Амар С. Баатарсүрэн
Байнгын хаяг	Хадгаламжийн даатгалын корпораци Санроуд Оффис, 3 давхар, Нарны зам 91 Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Улаанбаатар 14230, Монгол Улс Монгол улс, Улаанбаатар 14230, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Нарны зам 91, Санроуд Оффис барилга 3 давхар.	
Аудитор	БДО Аудит ХХК Юнион Бюлдинг В блок, 15-р давхар, 1502 тоот, Парисын гудамж, Нарны зам-62, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Улаанбаатар хот, Монгол Улс	

**2023 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
санхүүгийн тайлан бэлтгэх болон батлах талаарх
Удирдлагын Хариуцлагын Мэдэгдэл**

Энэхүү тайлангийн 3-5 дахь хуудсанд тусгагдсан хараат бус аудиторын тайланд дурдсан хараат бус аудиторын дүгнэлттэй хамт уншигдах дараах мэдэгдэл нь "Хадгаламжийн Даатгалын Корпораци"-ийн (цаашид 'ХДК' гэх) 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага болон аудиторын хариуцлагыг тусад нь илэрхийлэх үүднээс хийгдсэн болно.

ХДК-ийн удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС") -ын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй болно. Бид эдгээр санхүүгийн тайлантай холбоотой үүрэг хариуцлагаа ухамсарлан, санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС"), Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн гэдгээ баталж байна.

ХДК-ийн 2023 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрч батлав.


С. БААТАРСҮРЭН
Гүйцэтгэх захирлын үүрэг
Гүйцэтгэгч


Т. ӨЛЗИЙСҮРЭН
Санхүүгийн албаны дарга

Огноо: 2024.03.05

Улаанбаатар хот, Монгол улс



Tel: +976 77404040
 Fax: +976 77404041
 www.bdo.mn
 Zip code: 13110

Room 1502, Level 15
 Union Building - B, Paris Street
 Namji Zam - 62, Khoroo - 1
 Sukhbaatar District, Ulaanbaatar
 Mongolia

Утас: +976 77404040
 Факс: +976 77404041
 www.bdo.mn
 ШНК: 13110

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
 1-р хороо, Нарны зам - 62, Парисын
 гудамж, ЮНИОН БЮЛДИНГ Б блок
 15 - р давхар, 1502 тоот

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Хадгаламжийн Даатгалын Корпорацийн Үндэсний хороонд

Санхүүгийн тайлангийн аудитын талаарх тайлан

Дүгнэлт

“Хадгаламжийн Даатгалын Корпораци” (‘ХДК’ гэх) -ын дараах тайлангуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийлээ:

- 2023 оны 12 сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан;
- Энэ өдрөөр тасалбар болсон жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангууд; болон
- Нягтлан бодох бүртгэлийн томоохон бодлогуудын хураангуйг агуулсан санхүүгийн тайлангийн тэмдэглэлүүд.

Бидний дүгнэлтээр, хавсаргасан санхүүгийн тайлангууд нь ХДК-ийн 2023 оны 12 сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”) -ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (‘АОУС’) -ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл (‘НБЁЗОУСЗ’) -ийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм болон Монгол улсад мөрдүүлэхээр шаарддаг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу ХДК-с хараат бус байсан бөгөөд НБЁЗОУСЗ-ийн дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагын дагуу бусад ёс зүй: үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэж бид найдаж байна.



ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

Санхүүгийн тайланд Удирдлага ба Засаглах удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-ын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах, болон алдаа юм уу заль мэхнээс үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайлан бэлтгэх боломж бүрдүүлэхэд зайлшгүй шаардлагатай тийм дотоод хяналтыг тодорхойлох нь удирдлагын үүрэг хариуцлага юм.

Санхүүгийн тайланг бэлтгэж байхдаа удирдлага нь ХДК-ийг татан буулгах юм уу үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд удирдлага өөдрөг төсөөллөөр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх ХДК-ийн чадамжийг үнэлж, шаардлагатай бол өөдрөг төсөөлөлтэй холбоотой асуудлуудын талаар тодруулга хийх, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг ашиглах үүрэг хариуцлага хүлээнэ.

Үндэсний хороо нь ХДК-ийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Заль мэх эсвэл алдаанаас үүдсэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ ангид эсэх талаарх үл үндэслэлтэй баталгаажилтыг олж авч, өөрийн санал дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй баталгаажилт нь баталгаажилтын өндөр түвшин боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчлийг цаг ямагт илрүүлж байна гэж амласан баталгаа гаргадаггүй.

Алдаа зөрчил нь заль мэхнээс эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд хэрэв тэр нь дангаараа эсвэл нийлэхээрээ санхүүгийн тайланд үндэслэн түүнийг хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.




ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага (үргэлжлэл)

АОУС-ын дагуу хийсэн аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл гарган, аудитын туршид мэргэжлийн үл итгэх үзлийг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Заль мэх эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг алдаатай илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог олж авдаг. Заль мэхнээс үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг. Учир нь заль мэхэнд хуйвалдаан, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу тайлагнах, дотоод хяналтыг үл ойшоох явдлууд орсон байж болно.
- ХДК-ийн дотоод хяналтын үр ашигт байдлын талаар санал дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг боловсруулах зорилгоор аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын үл үндэслэлтэй байдлыг үнэлдэг.
- Мөн олж авсан аудитын нотолгоонд үндэслэн ХДК-ийн тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ төрүүлэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг удирдлага зохистойгоор хэрэглэсэн эсэхийг дүгнэдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа түүнтэй холбоотой санхүүгийн тайлангийн тодруулгад анхаарал хандуулах эсвэл хийсэн тодруулга нь хангалтгүй байна гэж үзвэл аудитын санал дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд суурилдаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөлүүд нь ХДК-г өөдрөг төсөөллөө үргэлжлүүлэхээ зогсооход хүргэх нөлөө үзүүлж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулга ба санхүүгийн тайлангууд нь үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ ба үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ ба хугацаа, аудитынхаа явцад олж илрүүлсэн дотоод хяналт дахь томоохон зөрчил дутагдлыг оруулаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад асуудлуудаар засаглах эрх бүхий удирдлагатай харилцдаг.



Л. БАЯРЦОГЗОЛ
УЛААНБААТАР ХОУ
“БДО Аудит” ХХК
МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОУ
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Парисын гудамж, Нарны зам-62
Юнион Бюлдинг В блок, 1502 тоот өрөө

Огноо: 2024 .03. 05

Хадгаламжийн Даатгалын Корпораци

2023 оны 12-р сарын 31-ний өдрөөрх
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

	Тэм	2023 оны 12 сарын 31 мян.төг	2022 оны 12 сарын 31 мян.төг
Хөрөнгө			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	7	465,060,777	231,709,857
Өмчийн хэрэглүүрээрх хөрөнгө оруулалт	8	190,077,000	222,666,000
Өрийн хэрэглүүрээрх хөрөнгө оруулалт	9	209,121,498	386,542,186
Эрх хүлээн авагчаас авах авлага болон бусад авлага	10	1,142,449	18,939,602
Даатгалын хураамжийн авлага	11	1,072,799	1,938,413
Өмч, барилга, тоног төхөөрөмж		1,039,470	1,069,533
Ашиглах эрхтэй хөрөнгө	12	1,135,760	-
Биет бус хөрөнгө		636,400	267,977
Бусад санхүүгийн бус хөрөнгө		138,105	116,229
Нийт хөрөнгө		869,424,258	863,249,797
Өр төлбөр			
Бусад өр төлбөр		6,316	13,774
Зээлийн өр төлбөр	13	190,077,000	284,958,901
Түрээсийн өр төлбөр	12	1,165,099	-
Нийт өр төлбөр		191,248,415	284,972,675
Өмч			
Оруулсан хөрөнгө	14	100,000,000	100,000,000
Хадгаламжийн даатгалын сан		578,175,843	478,277,122
Нийт өмч		678,175,843	578,277,122
Нийт өр төлбөр ба өмч		869,424,258	863,249,797

11-42 дүгээр хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

Хадгаламжийн Даатгалын Корпораци

2023 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

	Тэм	2023 он мян.төг	2022 он мян.төг
Даатгалын хураамж	15	67,688,855	48,197,230
Үр ашигт хүүгийн аргыг ашиглан тооцоолсон хүүгийн орлого	16	36,075,343	24,315,803
Үнэ цэнийн бууралтын гарз	17	(18,133,813)	(30,603,293)
Даатгалын болон хүүгийн орлогын цэвэр дүн		85,630,385	41,909,740
Санхүүгийн орлого	18	54,382,615	138,175,183
Санхүүгийн зардал	18	(33,572,333)	(137,981,141)
Ерөнхий ба удирдлагын зардал	19	(6,937,712)	(5,162,408)
Бусад орлого		395,766	13,936
Тайлант жилийн үр дүн		99,898,721	36,955,310

11-42 дүгээр хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

Хадгаламжийн Даатгалын Корпораци

**2023 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

	Хувьцаат капитал мян.төг	Хадгаламжийн даатгалын сан мян.төг	Нийт өмч мян.төг
2023 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	100,000,000	478,277,122	578,277,122
Тайлант жилийн үр дүн	-	99,898,721	99,898,721
2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	100,000,000	578,175,843	678,175,843
	Хувьцаат капитал мян.төг	Хадгаламжийн даатгалын сан мян.төг	Нийт өмч мян.төг
2022 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	100,000,000	441,321,812	541,321,812
Тайлант жилийн үр дүн	-	36,955,310	36,955,310
2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	100,000,000	478,277,122	578,277,122

11-42 дүгээр хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

Хадгаламжийн Даатгалын Корпораци

2023 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

	Тэм	2023 он мян.төг	2022 он мян.төг
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Тайлант жилийн үр дүн		99,898,721	36,955,310
<i>Тохируулга:</i>			
Өмч, барилга, тоног төхөөрөмжийн элэгдэл	19	209,478	221,122
Хөрөнгө ашиглах эрхийн хорогдуулга	19	126,196	245,773
Биет бус хөрөнгийн хорогдуулга	19	117,714	96,477
Авлагын үнэ цэнийн бууралтын гарз	17	18,133,813	30,603,293
ААБҮЦ-ээр хэмжигдэх хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн өөрчлөлт	18	32,790,055	(136,897,687)
ААБҮЦ-ээр хэмжигдэх зээлийн өр төлбөрийн бодит үнэ цэнийн өөрчлөлт	18	(32,589,000)	137,666,000
Гадаад валютын ханшийн зөрүүгийн хэрэгжээгүй олз	18	(743,293)	(1,277,187)
Санхүүгийн зардал	18	300,596	314,832
Хүүгийн орлого	16	(36,075,343)	(24,315,803)
Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		82,168,937	43,612,130
Авлагын (өсөлт)/бууралт		528,956	2,826,765
Бусад санхүүгийн бус хөрөнгийн өсөлт/(бууралт)		(21,876)	(22,849)
Бусад өр төлбөрийн өсөлт/(бууралт)		(7,458)	3,947
Ажлын капиталын өөрчлөлт		82,668,559	46,419,993
Хүлээн авсан хүү		21,268,453	14,486,700
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		103,937,012	60,906,693
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Худалдан авсан өмч, барилга, тоног төхөөрөмж		(179,416)	(242,997)
Худалдан авсан биет бус хөрөнгө		(486,138)	(20,054)
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх өрийн хэрэглүүрээрх хөрөнгө оруулалтад оруулсан мөнгө		(13,302,236)	(321,113,442)
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх өрийн хэрэглүүрээрх хөрөнгө оруулалт дүүсгавар болсноос хүлээн авсан мөнгө		185,588,605	5,000,000
ААБҮЦ-ээр хэмжигдэх өрийн хэрэглүүрээрх хөрөнгө оруулалтад оруулсан мөнгө		(6,203,161)	(5,946,945)
ААБҮЦ-ээр хэмжигдэх өрийн хэрэглүүрээрх хөрөнгө оруулалт борлуулснаас хүлээн авсан мөнгө		6,217,374	-
Хүлээн авсан ногдол ашиг		20,568,640	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		192,203,668	(322,323,438)

11-42 дүгээр хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

Хадгаламжийн Даатгалын Корпораци

2023 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН (үргэлжлэл)

	Тэм	2023 он мян.төг	2022 он мян.төг
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Зээлийн өр төлбөрийн эргэн төлөлт	23	(62,287,227)	(1,501,813)
Зээлийн өр төлбөрийн хүүгийн төлбөрийн төлөлт	23	(237,203)	(315,289)
Түрээсийн өр төлбөрийн үндсэн төлбөрийн төлөлт		(165,924)	(303,886)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		(62,690,354)	(2,120,988)
Тайлант жилийн нийт цэвэр мөнгөн гүйлгээ		233,450,326	(263,537,733)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	7	231,709,857	494,954,042
Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө		(99,406)	293,548
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7	465,060,777	231,709,857

11-42 дүгээр хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.



Монгол Улс, Улаанбаатар хот 14230,
Сүхбаатар дүүрэг 1-р хороо, Нарны зам-91
Санроуд оффис, 4 давхар



Утас: 976-70008448
Факс: 976-70008448



www.dicom.mn



www.facebook.com/DICOM.MN/